



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 227

Улаанбаатар хот

Зээлийн гэрээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Агаарын бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай” 88 дугаар тогтоол, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.10.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд хийгдэх 110/10 кВ-ын “Хүчит шонхор” дэд станц барих, цахилгаан дамжуулах агаарын шугамын дамжуулах чадварыг нэмэгдүүлэх төслийн ажлыг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр 17,000,000,000.00 (арван долоон тэрбум) хүртэл төгрөгийн зээлийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зээл, зээлийн хүүгийн нөхцөлийг судлан арилжааны банкт байгуулах эрх олгохыг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001901